

“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН 2018 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018.11.15

Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт			
Д/д	Хийх ажлын агуулга	Хийгдэх ажил	Хийгдсэн ажил
1.	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэд, ажилтнуудад сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хууль 5 дугаар зүйлийн 5.1.2;</li> <li>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5;</li> <li>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2.</li> </ul>	<p>1.1. Компанийн цахим хуудасны мэдээллийг тогтмолжуулах, үйл ажиллагааны ил байдлыг хангах, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллах.</p>	<p>“Шивээ-Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар “Мэдээллийн ил тод байдлын талаар төлөвлөгөө” батлан гаргасан.</p> <p>Уг тушаалаар “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” “Авилгын эсрэг хууль” “Шилэн дансны тухай” хуулийг хэрэгжүүлэх зорилгоор тус компанийн 2018 оны үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэдээлэх календарчилсан төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар баталсан. Төлөвлөгөөгөөр хийгдсэн ажлын мэдээллийг цаг хугацаанд нь компанийн цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулахыг Хүний нөөцийн албаны нийгмийн ажилтанд даалгаж, холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүргийг албан тушаалтнуудад үүрэг болгож шийдвэрлэсэн байна. Календарчилсан төлөвлөгөөнд дурьдсаны дагуу холбогдох мэдээллийг цаг алдалгүй хурдан шуурхай компанийн цахим санд байршуулан ажиллаж байна.</p>
		<p>1.2. Авлигатай тэмцэх газраас явуулж байгаа соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, сурталчилгаа, танилцуулга материалыг компанийн ажилтнуудад тогтмол танилцуулах.</p>	<p>Тус компани нь Авилгатай тэмцэх газраас явуулж байгаа соён гэгээрүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллаж, авилгагүй төр, авилга, хээл хахуульгүй орчинг бий болгох талаар идэвх санаачлага гарган ажиллаж байна.</p> <p>Авилгатай тэмцэх газар болон төрийн эрх бүхий</p>

			байгууллага, толгой компаниас ирсэн албан бичиг, хууль, дүрэм, журмыг холбогдох ажилтнуудад танилцуулан ажиллаж байна.
2.	<p>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5</li> </ul>	<p>2.1. УИХ, ЗГ, ИХТХ-ын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх, цахим хуудсандаа байршуулах</p> <p>2.2. Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөл, Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэх бодлогын баримт бичгийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх</p>	<p>Компанийн цахим хуудсанд хууль тогтоомж сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор 40 гаруй төрлийн хууль тогтоомжийг унших болон татан авах боломжтойгоор байрлуулсан болно.</p> <p>Компанийн цахим хуудасны холбоо тогтоох, өргөдөл, гомдол дэд цонхуудад иргэд, олон нийт, сонирхогч бүлэг санал, гомдолоо гаргах боломжтой байгаа болно.</p>
3.	<p>Төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b> Авилгын эсрэг хуулийн 6.1.3</p>	<p>3.1. Хяналт шалгалтын ажлын талаарх мэдээллийг байгууллагын самбар, цахим хуудсандаа байршуулах</p> <p>3.2. Хийсэн хяналт шалгалтын дүнг олон нийтэд мэдээлэх /цахим хуудсаар эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр/</p>	<p>Компанийн вэб сайтын мэдээлэл цонхонд дотоод хяналт шалгалт, санхүүгийн тайлан дэд хэсгүүдийг байршуулан ажиллаж байна.</p> <p>2018 онд Хувьцаа эзэмшигчийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэх бодлогын баримт бичгийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг тусгах тогтолцоог бий болгох талаар судалгаа хийж ажиллаж байна. Тусгайлан баталсан дүрэм, журам гаргаагүй байна.</p>
4.	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаараа/	4.1. Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор төсөв санхүүгийн орлого, зарлага зарцуулалтыг хариуцаж	“Шивээ-Овоо” ХК нь төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын цахим хуудас, шилэн дансны вэб хуудсанд санхүүгийн хагас, бүтэн жилийн тайлан, Санхүүгийн эдийн засгийн хэлтсийн бүтэц, орон тоо болон тус компанид санхүү, эдийн засгийн хувьд

	<p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;</li> <li>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6 дугаар зүйлийн 6.4, 6.8.3</li> </ul>	<p>ажилладаг ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн хэлтсийн хэвийн үйл ажиллагааг хангах.</p>	<p>мөрдөж байгаа дүрэм, журмын жагсаалтыг байрлуулан ажиллаж байна. Цаг хугацаанд нь мэдээллээ оруулан ажиллаж байна.</p>
		<p>4.2. Жилийн эцсийн санхүүгийн тайлан, тухайн жилийн төсөв, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг тогтмол цахим хуудсаар мэдээлж байх.</p>	<p>2018 онд “Шивээ-Овоо” хувьцаат компани өөрийн цахим хуудсанд улирал бүрийн санхүүгийн тайлан, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг байрлуулан, төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.</p>
<p>5.</p>	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, 6.1.6;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1</li> </ul>	<p>5.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Хэлтэс хэсэг нэгжийн удирдлага зэрэг удирдах албан тушаалтнуудын танилцуулга, эрхлэх үйл ажиллагааны талаар цахим хуудсандаа баяжуулан байршуулах, аливаа өөрчлөлт орсон тохиолдолд 7 хоногт багтаан тухай бүр шинэчилж байх.</p> <p>5.2. Нээлттэй ажлын байр, сул орон тооны зарыг мэдээлэх.</p> <p>5.3. Компанийн ажилтнуудыг сонгон шалгаруулах журмыг нээлттэй болгох</p> <p>5.4. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж, батлуулах</p>	<p>Компанийн цахим мэдээллийн сангийн мэдээлэл цонхны дэд хэсэгт Хувьцаа эзэмшигч болон Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол шийдвэр хэсэгт Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг тогтмол байрлуулж байна</p> <p>Компанийн цахим санд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Хэлтэс нэгжийн удирдлагын танилцуулга, эрх үйл ажиллагааны талаар тогтмол мэдээллийг тавьж цахим сангийн мэдээллийн баяжилтыг тогтмол хийж байна.</p> <p>Компани хүрэн нүүрс олборлолтын уул, уурхайн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд чадварлаг, мэдлэг бүхий ажилтан шалгаруулж авах нэн чухал асуудлын нэг юм.</p> <p>Компанийн цахим хуудасны Хүний нөөц цонхны дэд, хэсгүүдэд тус компанийн “Хүний нөөцийн” чиглэлээр явуулах бодлого, “Ажилтан сонгон шалгаруулах журам” хүний нөөцийн ажилтан сонгон шалгаруулах зар, мэдээллийг байршуулсан бөгөөд ажилтан сонгон шалгаруулах зарыг журамд заасны дагуу аймаг, орон нутгийн хөдөлмөрийн зарын вэб хуудас, компанийн цахим хуудас, хэлтэс, алба, хэсгийн мэдээллийн самбарт нээлттэйгээр байршуулж чадвар, мэргэшсэн, мэдлэг бүхий ажилтныг сонгон шалгаруулж ажилд авч байна.</p> <p>Компанийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах</p>

			зорилгоор хамтын гэрээ, “Хүний хөгжилд түшиглэн бүтээмж дээшлүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам” “Орон сууц хуваарилах, ашиглалтанд хяналт тавих журам” “Орон сууц хувьчлах журам” “Уурхайчдын спорт заалны ажиллах журам” гэх мэт журам, дүрмээр ажилчдын нийгмийн баталгааг хангах олон талт ажлыг зохион байгуулж байна.
6.	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;</li> <li>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6;</li> <li>• Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5</li> </ul>	<p>6.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер сонгон шалгаруулалтын зар, худалдан авах ажиллагааны явж, үр дүнг цаг хугацаанд нь тогтмол мэдээлж байх.</p>	<p>“Шивээ-Овоо” ХК-ийн 2018 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөг компанийн веб хуудас болон Төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн цахим систем /tender.gov.mn/ сайтад тогтмол байрлуулан ажиллаж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Авилгын эсрэг хуульд заасны дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод байдлаар зохион явуулж байна.</p>
		<p>6.2. Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас болон өөрийн цахим хуудсанд худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тогтмол байршуулж хэвшүүлэх.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын худалдан авах ажиллагааны нэгдсэн цахим сан болон тус компанийн цахим хуудсанд худалдан авах ажиллагааны цэсэнд мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна.</p>
7.	<p>Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг</li> </ul>	<p>7.1. Компанийн ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүнг хамт олонд тогтмол мэдээлж байх, компанийн ёс зүйн дүрэм шинэчлэн баталж, мөрдүүлэх.</p>	<p>“Шивээ-Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар “Ёс зүйн дүрэм”-ийг батлан мөрдөн ажиллаж байна.</p> <p>Шинэчлэн баталсан ёс зүйн дүрмээр компанийн үнэт зүйл, ёс зүйн хэм хэмжээг тодорхой болгосон бөгөөд хөгжлийн чиг хандлагатай уялдуулан ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, харилцагчийг хүндэтгэн харилцах, удирдах, удирдуулах, хэвлэл мэдээлэл, олон нийтийн</p>

	<p>сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.2;</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.9, 6.8</li> </ul>		<p>хэрэгсэл, цахим сүлжээг ашиглах, иргэний ба улс төрийн эрх, эрх чөлөө, нийгмийн хариуцлага гэсэн дэд хэсгүүд нь шинээр батлагдсан гарсан, хууль, дүрэм, журамд ёс зүйн дүрэм бүрэн нийцэж нийт ажилтнуудын эрх ашиг сонирхлыг бүрэн хангах боломжтой болсон.</p> <p>“Шивээ-Овоо” ХК-ийн Ёс зүйн хороог тус компанийн Гүйцэтгэх захирлын 2015 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 тушаалын 2 дугаар хавсралтаар 7 ажилтаны бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан юм.</p> <p>Ёс зүйн хороонд 2018 онд ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол ирээгүй байна.</p>
		<p>7.2. Компанийн нийт ажилтнуудын харилцаа, хандлага, ёс зүйн ухамсрыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, нээлттэй хэлэлцүүлэг тогтмол хийж байх, ёс зүйн дүрмийг байгууллагын цахим санд байршуулах.</p>	<p>“Шивээ-Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар “Ёс зүйн дүрэм”-ийг компанийн цахим санд байршуулсан.</p> <p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ажилчдын санал, хүсэлтийг харгалзан байгууллага ажилчдын харилцаа, хандлагыг шинэ түвшинд гаргах, ёс зүйн ухамсрыг дээшлүүлэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүднээс 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдөр нийт ажилчдад “Өөртөө итгэлтэй амьдрал, өөртөө амьдралын гайхамшиг бай” сэдвийн хүрээнд лекц зохион байгуулж уурхайн 200 гаруй ажилтан тэдгээрийн гэр бүлийн гишүүд, иргэдийг хамруулсан болно.</p> <p>“Шивээ-Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2015.03.31-ний өдрийн А/30 дугаар “Авилга, гэмт хэрэг, зөрчил, архи дан согтуурахаас урьдчилан сэргийлэх зааврыг” ажилтан бүрт танилцуулан ажиллуулж байна.</p> <p>Компанийн Хүний нөөцийн албанаас удирдах албан тушаалтан, инженер техникийн ажилтнуудын ёс зүй, зан харьцаа, сэтгэл ханамжийн талаарх судалгааг түүвэрчилсэн байдлаар ажилтнуудаас авч судалгаанд үнэлэлт өгөн ажиллаж байна.</p>

8.	<p>Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10;</li> </ul>	<p>8.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, Захирлын зөвлөлийн хурлын шийдвэр, Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэрийн талаар ажилтнуудад болон олон нийтэд мэдээлэх зорилгоор компанийн цахим хуудас болон хэлтэс, алба, хэсэг нэгжийн мэдээллийн самбарт мэдээлж хэвшүүлэх,</p>	<p>Компанийн цахим хуудас, хэсэг, нэгжүүдийн мэдээллийн самбарт Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, Захирлын зөвлөлийн шийдвэрийг тогтмол байршуулж байна.</p> <p>Мөн шаардлагатай бусад асуудлыг тус компанийн хэлтэс, алба, хэсэг, нэгжийн мэдээллийн самбарт байрлуулж иргэд, ажилчид мэдээлэл авах эрхийг ханган ажиллаж байна.</p>
9.	<p>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг мэдээллийн самбар, цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах.</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4</li> </ul>	<p>9.1. Компанийн үйл ажиллагааныхаа хүрээнд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн акт дүрэм журмыг мэдээллийн самбар, цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах, өөрчлөлт орсон тохиолдолд цаг тухай бүр шинэчлэлт хийж хэвшүүлэх.</p> <p>9.2. Компанийн хэмжээнд дотооддоо дагаж мөрдөхөөр батлан гаргасан дүрэм, журмыг иргэд олон нийт, харилцагч байгууллагатай хамаарал бүхий журмуудыг татаж авах болон унших боломжтойгоор, компанийн нууцын журамд заасан дүрэм, журам, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичиг зэргийг нэр томъёоны жагсаалт байдлаар цахим хуудсандаа байршуулж</p>	<p>“Шивээ-Овоо” ХК-ийн үйл ажиллагааны хүрээнд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, эрх зүйн акт, дүрэм, журмыг тус компанийн вэб сайтын хууль, эрх зүйн цонхонд байршуулан ажиллаж байна. Хууль эрх зүйн цонхонд 41 хууль тогтоомж, компанийн хэмжээнд мөрдөж буй дүрэм журмын жагсаалт, дүрэм, журмыг байрлуулсан байгаа болно. Сонирхсон иргэд компанийн вэб сайтанд хандаж мэдээлэл авах бүрэн боломжтой.</p> <p>Компани өөрийн вэб сайтын дээрхи цонхоор дамжуулан хууль сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Тус компанийн вэб хуудсанд байрлаж буй “Хууль, эрх зүйн” цонхонд “Шивээ-Овоо” хувьцаат компанид дотооддоо мөрдөгдөж буй дүрэм, журмыг жагсаалтыг байрлуулан ажиллаж байна.</p> <p>Дээрхи дүрэм, журмын жагсаалтыг байршуулахдаа компанийн нууцын журамд заасны дагуу бизнесийн үйл ажиллагаатай холбоотой, бодлогын баримт бичгийг эх тавиагүй бөгөөд нэр томъёоны жагсаалт байдлаар цахим хуудсанд байршуулж байна.</p> <p>Иргэд, харилцагч байгууллага, хамаарал бүхий талууд компанийн дотоод журам, ёс зүйн дүрэм, бусад илээр байрлуулсан журам, дүрэмтэй танилцаж мэдээлэл авах бүрэн боломжтой болно.</p>

		ХЭВШИХ.	
10.	<p>Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах.</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2;</li> <li>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3;</li> </ul>	<p>10.1. Албан байгууллага болон иргэд, ажилчдаас ирүүлсэн аливаа хүсэлт, санал, гомдлыг хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх, хариу өгөх механизмыг боловсронгуй болгож, журамлах.</p>	<p>“Шивээ-Овоо” хувьцаат компани ажилчид, иргэд, албан байгууллагаас ирүүлсэн аливаа, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг компанийн бичиг хэрэг хариуцсан ажилтан хүлээн авч ирсэн бичгийн бүртгэн авч холбогдох албан тушаалтанд шилжүүлэн хуулийн хугацаанд шийдвэрлэж байна.</p> <p>Авилгын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад заасан мэдээллийг хүлээн авах этгээдийг тодорхой болгож, иргэдийг чирэгдүүлэхгүй байх, өргөдөл, гомдлыг хүлээн авахгүй ажлын давхардал үүсгэж төөрөгдүүлэх, өргөдөл гомдол хүлээн авах ажилтны хаяг, ажлын цагийн горим, өрөөний хаягжилтыг хуульд заасан зохицуулалтаар хийн ажиллаж байна.</p> <p>Энэ ч үүднээс тус компани “Шивээ-Овоо” ХК-ийн төв байранд мөрдөх журмыг Гүйцэтгэх захирлын 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/78 дугаар тушаалаар батлан мөрдөж байна.</p>
		<p>10.2. Цахим хуудсаар болон, цахим шуудангаар дамжуулан санал гомдол хүлээж авах, хариу өгөх тогтолцоог тодорхой асуудлуудын хүрээнд авах боломжоор хангаж, тогтолцоог бий болгох.</p>	<p>“Шивээ-Овоо” ХК нь мэдээллийн ил тод байдал, Авилгатай тэмцэх газраас гаргасан зөвлөмжийн хүрээнд тус компанийн Вэб сайтанд өргөдөл, гомдол хүлээн авах цонхыг нээсэн бөгөөд иргэд дээрхи вэб сайтын цонхыг ашиглан өөрийн санал, хүсэлт, өргөдөл, гомдолоо чөлөө гаргах боломжтой болно.</p>
		<p>10.3. Хүсэлт, санал гомдлын шийдвэрийн талаар цахим хуудсаар дамжуулан сар бүр тогтмол мэдээллийг байршуулж хэвшүүлэх.</p>	<p>Иргэд, ажилчид, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдлыг улирал бүрээр “Шивээ-Овоо” хувьцаат компани вэб сайт дахь өргөдөл, гомдол цонхонд байрлуулж холбогдох мэдээллийг өгч байна.</p> <p>2018 онд иргэд, ажилчид тус компанид 271 санал, хүсэлт, гомдол ирснийг шийдвэрлэж хариуг өгсөн байна. Иргэд, ажилчдаас ирсэн гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн</p>

			талаархи тоон мэдээллийг компанийн цахим хуудсанд байрлуулсан байна.
11.	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12;</li> <li>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1</li> </ul>	<p>11.1. Авлигад өртөж болох ажлын байрны судалгааг санал асуулга болон ажлын байрны чиг үүргийнх нь хүрээнд судалгаа хийж жагсаалтыг гаргах. Гаргасан жагсаалтын дагуу холбогдох ажлын байрууд дээр Авлигын эсрэг хуулийн талаар сургалт зохион байгуулах. Ажлын байрны тодорхойлолт, дотоод зохион байгуулалтыг өөрчлөх замаар гарч болох эрсдэлийг бууруулах арга хэмжээг дотооддоо зохион байгуулах.</p>	<p>“Шивээ-Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/45 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын жагсаалт”-ыг шинэчлэн баталсан болно.</p> <p>Компанийн эрх бүхий албан тушаалтнуудаас хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд авч хэвшсэн болно.</p> <p>2018 оны 11 дүгээр сард Говьсүмбэр аймгийн Прокурорын газартай хамтарч хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг эрх бүхий албан тушаалтан болон компанийн хэлтэс, хэсэг, албадын дарга нарт -Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ дахь “Албан тушаалын гэмт хэргийн тухай”</p> <p>- Хөрөнгө орлогын мэдүүлэг сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан.</p> <p>Ажилд шинээр орж буй ажилтанд тус компанийн Гүйцэтгэх захирлын 2015.03.31-ний өдрийн А/30 дугаар “Авилга, гэмт хэрэг зөрчил, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх заавар”-ыг хуулийн зөвлөх танилцуулж зохих зааварчилгааг өгөн ажиллаж байна.</p> <p>“Шивээ-Овоо” ХКомпани ажилчдын хууль, эрх зүйн мэдлэлийг дээшлүүлэх зорилгоор Говьсүмбэр аймгийн Хууль зүйн хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс, Говьсүмбар аймаг дахь Авилгатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн дэд зөвлөлтэй хамтарч:</p> <p>- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль</p> <p>“Говьсүмбэр аймгийн Прокурорын газар”-тай хамтарч</p> <p>- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/</p> <p>Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10 дугаар бүлэг Хүний амьд явах эрхийг эсрэг гэмт хэрэг, 11 бүлэг Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 16-р бүлэг</p>



			<p>Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, 17-р бүлэг өмчлөх эрхийг эсрэг гэмт хэрэг гэх мэт”  “Зөрчлийн тухай хууль”  “Захиргааны Ерөнхий хууль” сонсох ажиллагаа,  “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”  “Хөдөлмөрийн аюулгүй байдал түүний ойлголт” талаархи хууль, эрх зүйн суурь мэдлэгийг олголоо.  2018 онд тус компаний нийт 152 ажлын байрны тодорхойлолтыг өөрчилж ажилтнуудын ажиллах нөхцөл, чиг үүргийг тодорхойлж ажлын давхардал, ачааллыг арилгасан байна.</p>
		11.2. Эрх бүхий албан тушаалтныг томилох, АТГ-аас зохион байгуулсан сургалтад ЭБАТ-ыг хамруулах,	<p>Компанийн эрх бүхий албан тушаалтнуудаас хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах ажилтанг тус компанийн хуулийн зөвлөхийг томилсон болно. Авилгатай тэмцэх газраас 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам” “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам” “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх хадгалах, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам”-ын төслийн хэлэлцүүлэгт ЭБАТ-ыг хамруулсан болно.</p>
<b>Авилгатай тэмцэх санал, санаачилга</b>			
12.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	12.1. Авилгалын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, тайлагнаж ажиллах.	<p>“Шивээ-Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/09 дүгээр “Төлөвлөгөө батлах” тухай тушаалаар тус компанийн авилгалын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдан гарсан. Төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан авилгын эсрэг явуулсан тайланг “Авилгатай тэмцэх газар”-т жил бүр хүргүүлэн ажиллаж байна.</p>

		<p>12.2. Авлигын эсрэг хуулийг сурталчлах, тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, шинжилгээ хийх ажлыг төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх, үр дүнг тайланд тусгах,</p>	<p>Авилгалын эсрэг хуулийг сурталчлах, байгаль орчноо хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэх зорилгыг тус компани гол чиглэлээ болгон ажилладаг болно. Тус компани “2018 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г батлан гаргаж өөрийн компанийн Вэб сайтанд байрлуулан төлөвлөгөөг мөрдөн ажиллаж байна. Уурхайн хамт олны үндсэн зорилт нь “Байгаль орчинд ээлтэй, аюулгүй үйлдвэрлэл, өндөр бүтээмж бүхий уул уурхайн салбарын жишиг компани болох” юм.</p>
		<p>12.3 Авлигын эсрэг үйл ажиллагаанд тусгайлан хөрөнгө гаргах,</p>	<p>Компани жил бүрийн төсөвт авилга, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах, нийтийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн ажлыг өрнүүлэхтэй холбоотойгоор төсөвт тодорхой хэмжээний зардал суулган ажиллаж байна.</p>
		<p>12.4. Удирдах албан тушаалтны үлгэр жишээч байдлын талаар ажилтнуудаас өгөх үнэлгээний судалгааг явуулах</p>	<p>Ажилтан болон удирдах албан тушаалтан, инженер техникийн ажилтнуудын ёс зүй, зан харьцаа, үлгэр жишээч байдлын талаарх судалгааг компанийн Хүний нөөцийн албанаас 2018 оны 8-9 дүгээр сард явуулсан.</p>
<p>13.</p>	<p>Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх</p>	<p>13.1. ИТА-уудын ажлын төлөвлөгөө тайлан, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэж ил тод болгох.</p>	<p>“Шивээ-Овоо” ХК-ийн хөдөлмөрийн дотоод журманд инженер, техникийн болон уурхайн нийт ажилчид жил, улирал, сараар ажлын төлөвлөгөө гарган ажлын гүйцэтгэлийг тайлагнан ажилладаг болно. Хөдөлмөрийн дотоод журмын 4.4.Хэлтэс, алба, хэсэг нэгжийн дарга нар ажилаа сар, улирал, жилээр төлөвлөн нэгжийн ажилтнуудын саналыг тусган боловсруулж харьяа Хэлтсийн дарга болон Захирлаар батлуулан хэрэгжүүлнэ. 4.5.Нэгжийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг сар бүр дүгнэн тайлан гаргаж нэгжийн ажилтнуудын хурлаар хэлэлцүүлэн биелэлтийг хангаж ажиллана. 4.6.Компанийн ажилтан нь ажлаа сараар төлөвлөж харьяалагдах хэлтэс алба, хэсэг нэгжийн даргаар батлуулан мөрдөж ажиллана. 4.7.Ажилтан нь сар бүр хийж гүйцэтгэсэн ажлынхаа тайланг өөрийн нэгжийн даргад гаргаж өгөх ба тухайн</p>

			<p>нэгжийн удирдлага дүгнэж биелэлтийг нь хангуулж ажиллана байна.</p> <p>“Шивээ-Овоо” хувьцаат компани үйл ажиллагааныхаа төлөвлөгөө, тайланг компанийн дотоод журамд заасны дагуу хүлээн авч хурлаар хэлэлцүүлдэг учир ажилчид ажлын гүйцэтгэл болон төлөвлөгөө, тайлангийн талаар ямар нэг гомдол гаргаагүй болно.</p> <p>Мөн компани нь долоо хоног бүрийн Даваа гарагийн 16<sup>30</sup> цагаас Удирдлагын шуурхай зөвлөгөөн, 17<sup>30</sup>-цагаас Үйлдвэрлэлийн нэгдсэн зөвлөгөөн хийж зөвлөгөөнөөр өнгөрсөн долоо хоногт гүйцэтгэсэн ажил, удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт, явцын талаар нэгжийн дарга бүрийн мэдээллийг сонсож, ирэх долоо хоногт гүйцэтгэх ажил, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон ХАБЭА-н талаар холбогдох ажлын чиглэлийг Гүйцэтгэх захирал, түүний эзгүйд дэд захирлууд өгдөг болно.</p>
14.	АТГ-аас гаргасан шийдвэрийг биелүүлэх	14.1. АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж, мэдэгдэл, шаардлага зэргийн биелэлтийг хангаж ажиллах	<p>Авилгатай тэмцэх газрын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн №01/8723 дугаар зөвлөмжийн дагуу 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Говьсүмбэр аймгийн Хууль зүйн хэлтсийн дарга Д.Магвансүрэн, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэ, Говьсүмбар аймаг дахь Авилгатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн дэд зөвлөлийн гишүүн Д.Зандаръяа нараар “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан “Албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана” гэсэн сэдвийн хүрээнд “Шивээ-Овоо” ХК-ийн эрх бүхий албан тушаалтнууд, тус компанийн Гүйцэтгэх захирлын 2018.01.18-ны өдрийн А/08 дугаар “Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалын дагуу томилогдсон үнэлгээний хорооны гишүүдэд сургалт зохион байгуулсан байна.</p>

15.	Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх	15.1. Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, АТГ-т хүргүүлэх,	“Шивээ-Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар “2018 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан Авилгатай тэмцэх газар хүргүүлсэн.
		15.2. Хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 15-ны дотор АТГ-т хүргүүлэх.	“Шивээ-Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар “2018 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн.

ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАСАН:  
ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

Э.МАНДАХНАРАН

----o00Oo----